



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ
СОНИРХОГЧ ЭТГЭЭДҮҮДЭД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр, Б корпус,
Утас/Факс: (976-51) 26 00 62,

И-мэйл: info@spa.gov.mn, Вэбсайт: www.spa.gov.mn

2020.06.30 № А-1) 1364

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх

тухай

Тус газраас 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдөр зарласан II.4.3.1 “МОНЦАМЭ агентлагийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/” төсөл арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс тодруулга ирүүлсэнтэй холбогдуулан дараах хариуг хүргүүлж байна.

	Сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулга	Тодруулгын хариу
1	Багц-1 Техникийн шаардлага 12 дугаар зүйлд шаардсан ажлыг хийж гүйцэтгэх, үнэлгээг гаргахын тулд а.Байгууламжтай танилцах хүсэлтэй байна. б. Байгууламжийн зураг төсөлтэй танилцах хүсэлтэй байна.	Оролцогч, сонирхсон этгээд нь Техникийн шаардлагад дурдсан ажлыг хийж гүйцэтгэх, суурилуулах ажлын талбай, байгууламжийн зураг төсөлтэй байгууллагын төв байранд ажлын цагаар ирж танилцах бүрэн боломжтой.
2	Багц-1 Техникийн шаардлага 16 дугаар зүйл болон 17 дугаар зүйл хоорондоо зөрчилдөж байгаа тул аль үзүүлэлтийг нь эхний ээлжинд хангасан байвал зохих вэ?	www.tender.gov.mn цахим хуудасны “МОНЦАМЭ агентлагийн тоног төхөөрөмж” ТХААГ/202005007 дугаартай тендерийн нүүр хуудасны Холбогдох бичиг баримтууд хэсгийн ТЭЗҮ талбарт байршүүлсан “Мэдээллийн монцамэ агентлаг.pdf” нь 3 багц тендерийн үндсэн техникийн шаардлага, ажлын даалгавар болно.
3	ТӨӨЗ 4.2.2 Нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай тодорхойлолт Засгийн газрын шийдвэрээр ААН-ийг 2020.04.01-ээс 2020.10.01 өдрийг хүртэл чөлөөлсөн байгаа. Иймд тодорхойлолтыг заавал авах уу?	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1.2.Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй; бол ерөнхий нөхцөлийг хангаагүй гэж үзэх тул ТШӨХ-ийн ТӨӨЗ 4.2.2-д заасан шаардлагыг хангаж ирүүлэх шаардлагатай.
4	Нийгмийн даатгалын систем нь цахимаар тодорхойлолт авч болдог болсон. Цахим тодорхойлолт хавсаргаж болох уу?	Нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай тодорхойлолтыг цахим хэлбэрээр болон албан тоот хэлбэрээр хавсарган ирүүлж болно.

Дээрх тодруулгатай холбоотой уг төсөл арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

1.ТӨӨЗ 21.1 Тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа нь: 2020 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал.

2.ТӨӨЗ 24.1 Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: 2020 оны 7 дугаар сарын 06-ны өдөр. Цаг: 11 цаг 00 минут.

3.ТООЗ 28.1 Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: 2020 оны 7 дугаар сарын 06-ны өдөр. Цаг:11 цаг 30 минут

Жич:Захиалагчаас ирүүлсэн тодруулгын хариуг хавсаргав.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.УЛАМ-ӨРНӨХ